

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 03 сарын 11-ны өдөр

Дугаар ...

БА - 079/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянгол дүүргийн 29 дүгээр хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьгүй 1 давхар 1 блок хүйтэн агуулахын барилга, зорьгүй 5 давхар 1 блок хүнсний үйлдвэрийн барилга, зорьгүй 1 давхар 1 блок сүү, сүүн бүтээгдэхүүн, жимс боловсруулах үйлдвэрийн барилга, зорьтой 3 давхар 1 блок, 12 автомашины дулаан зогсоолтой оффисын барилга, нийт 4 блок бүхий хүчин чадалтай үйлдвэр, агуулахын цогцолборын зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 сарын 31-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/08/03 огноо, 2023/499 дугаар;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар - PCDP-07/2023, PCDP-06/2023, АВ-01.01/2024, АВ-01/2023

2.3. Захиалагч: Юнион капитал инвестмент ХХК оноосон нэр, 9011825273 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6671489 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 29 дүгээр хороо, (хуучинаар 20-р хороо) Дунд гол БГД, Өөрийн байр -00 тоот, 99229158 холбоо барих утас, Batjargal@teso.mn цахим хаяг;

Хөсөг трейд ХХК оноосон нэр, 9010001052 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2037467 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 29 дүгээр хороо, (хуучинаар 20-р хороо) Дунд гол БГД, Өөрийн байр -00 тоот, 99229158 холбоо барих утас, Batjargal@teso.mn цахим хаяг;

Милко ХХК оноосон нэр, 9011209006 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5327059 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 29 дүгээр хороо, (хуучинаар 20-р хороо) Дунд гол БГД, Өөрийн байр -00 тоот, 99229158 холбоо барих утас, Batjargal@teso.mn цахим хаяг;

2.4. Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч: Ингүүмэл үйлс ХХК оноосон нэр, 9011764100 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6347975 регистрийн дугаар, БУ18-185/19 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг:

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР**

Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 1 дүгээр хороо үйлдвэр,хд-34, 4 тоот 99097863 холбоо барих утас, inguumel@gmail.com цахим хаяг;

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: ЭЙ БИ ӨҮ МАРОН ТИССЕН ГРУПП ХХК оноосон нэр, 9011613051 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6075428 регистрийн дугаар, ӨБ12-567/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 5-р хороолол, энхтайвны өргөн чөлөө, 59, 18 давхар, 80057010 холбоо барих утас,

Баянзуух констракшн ХХК оноосон нэр, 9011227127 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5366453 регистрийн дугаар, БУ12-563/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 15 дугаар хороо, Өнөр хороолол, москва 44, 17 тоот, 99114419 холбоо барих утас,

Металл велдинг ХХК оноосон нэр, 9011822876 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6637809 регистрийн дугаар, БУ11-1090/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 18 дугаар хороо, 4 хороолол, жалханц хутагт, 35в, 98 тоот, 99097276 холбоо барих утас,

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Пи си ди пи оноосон нэр, 9011392005 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5669995 регистрийн дугаар, ЗТ18-339/22 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1 дүгээр хороо, 19-р хороолол 1 тоот, 99880816 холбоо барих утас, PCDP@gmail.com цахим хаяг;

Адапт бюлд ХХК оноосон нэр, 9011849451 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 8324301 регистрийн дугаар, ЗТ12-535/23 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо, 14-р хороолол, 57-р байр 14 тоот, 88014486 холбоо барих утас, Tserennadmid.b@gmail.com цахим хаяг;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Милко ХХК оноосон нэр, 9011209006 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5327059 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 29 дүгээр хороо, (хуучинаар 20-р хороо) Дунд гол БГД, Өөрийн байр -00 тоот, 99229158 холбоо барих утас, Batjargal@teso.mn цахим хаяг;


2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:



- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 1 давхар 1 блок хүйтэн агуулахын барилга, зоорьгүй 5 давхар 1 блок хүнсний үйлдвэрийн барилга, зоорьгүй 1 давхар 1 блок сүү, сүүн бүтээгдэхүүн, жимс боловсруулах үйлдвэрийн барилга, зоорьтой 3 давхар 1 блок, 12 автомашины дулаан зогсоолтой оффисын барилга, нийт 4 блок бүхий хүчин чадалтай үйлдвэр, агуулахын цогцолборын зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 4 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 1 давхар 1 блок хүйтэн агуулахын барилга, зоорьгүй 5 давхар 1 блок хүнсний үйлдвэрийн барилга, зоорьгүй 1 давхар 1 блок сүү, сүүн бүтээгдэхүүн, жимс боловсруулах үйлдвэрийн барилга, зоорьтой 3 давхар 1 блок, 12 автомашины дулаан зогсоолтой оффисын барилга, нийт 4 блок бүхий хүчин чадалтай үйлдвэр, агуулахын цогцолборын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Баянгол дүүргийн 29 дүгээр хороо, Юнион капитал инвестмент ХХК, Хөсөг трейд ХХК, Милко ХХК-ийн захиалгатай, зоорьгүй 1 давхар 1 блок хүйтэн агуулахын барилга, зоорьгүй 5 давхар 1 блок хүнсний үйлдвэрийн барилга, зоорьгүй 1 давхар 1 блок сүү, сүүн бүтээгдэхүүн, жимс боловсруулах үйлдвэрийн барилга, зоорьтой 3 давхар 1 блок, 12 автомашины дулаан зогсоолтой оффисын барилга бүхий үйлдвэр, агуулахын цогцолбор

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Захиалагч юнион капитал инвестмент ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



(М.Эрдэнэсүх)

Хөсөг трейд ХХК-ийн гүйцэтгэх захирал

(М.Эрдэнэсүх)

Милко ХХК-ийн захирал



(Б.Түвшинжаргал)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 29 ДҮГЭЭР ХОРОО, ЮНИОН КАПИТАЛ ИНВЕСТМЕНТ ХХК, ХӨСӨГ ТРЕЙД ХХК, МИЛКО ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬГҮЙ 1 ДАВХАР 1 БЛОК ХҮЙТЭН АГУУЛАХЫН БАРИЛГА, ЗООРЬГҮЙ 5 ДАВХАР 1 БЛОК ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН БАРИЛГА, ЗООРЬГҮЙ 1 ДАВХАР 1 БЛОК СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ЖИМС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН БАРИЛГА, ЗООРЬТОЙ 3 ДАВХАР 1 БЛОК, 12 АВТОМАШИНЫ ДУЛААН ЗОГСООЛТОЙ ОФФИСЫН БАРИЛГА, НИЙТ 4 БЛОК БҮХИЙ ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН ЦОГЦОЛБОРЫН БАРИЛГЫГ БАЙНГЫН АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дүгээр сарын 31

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 29 дүгээр хороо, Юнион капитал инвестмент ХХК, Хөсөг трейд ХХК, Милко ХХК-ийн захиалгатай, зoorьгүй 1 давхар 1 блок хүйтэн агуулахын барилга, зoorьгүй 5 давхар 1 блок хүнсний үйлдвэрийн барилга, зoorьгүй 1 давхар 1 блок сүү, сүүн бүтээгдэхүүн, жимс боловсруулах үйлдвэрийн барилга, зoorьтой 3 давхар 1 блок, 12 автомашины дулаан зогсоолтой оффисын барилга, нийт 4 блок бүхий үйлдвэр, агуулахын цогцолборын барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын хурал 2025 оны 01 сарын 31-ний өдрийн 15:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж 17:00 цагт дуусав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс

Хуралд:

1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Мөнгөн
2. Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч Г.Батбаатар
3. Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч З.Очирпүрэв
4. Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын хэсгийн ахлагч Б.Дашдорж
5. Барилга хөгжлийн төв, Барилга барилгын материал үйлдвэрлэлийн хэлтэсийн инженер О.Ундрах
6. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер Г.Үүрийнгэгээ
7. Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Н.Болор-Эрдэнэ
8. Нийслэлийн Онцгой байдлын газар, Барилгын зураг төслийн хяналтын байцаагч, хошууч Б.Даваасүрэн
9. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, ШХХА-ны холболтын инженер М.Мөнхтөр
10. Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч Э.Шижиртуяа

11. Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэний Эрхийг Хамгаалах Байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан	Б.Ганбаатар
12. Юнион капитал инвестмент ХХК-ийн гүйцэтгэх захирал	М.Эрдэнэсүх
13. Зураг төсөл зохиогч Аж групп ХХК-ийн төлөөлөл	Б.Энхболд
14. Зураг төсөл зохиогч Адапт бюлд ХХК-ийн төлөөлөл	Н.Цэрэннадмид
15. Ерөнхий гүйцэтгэгч Ингүүмэл үйлс ХХК-ийн төлөөлөл	Б.Анхбаяр

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан - 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан - 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянгол дүүргийн 29 дүгээр хороо, Юнион капитал инвестмент ХХК, Хөсөг трейд ХХК, Милко ХХК-ийн захиалгатай, зорьгүй 1 давхар 1 блок хүйтэн агуулахын барилга, зорьгүй 5 давхар 1 блок хүнсний үйлдвэрийн барилга, зорьгүй 1 давхар 1 блок сүү, сүүн бүтээгдэхүүн, жимс боловсруулах үйлдвэрийн барилга, зорьтой 3 давхар 1 блок, 12 автомашины дулаан зогсоолтой оффисын барилга, нийт 4 блок бүхий үйлдвэр, агуулахын цогцолборын барилгыг байнгын ашиглалтад оруулах комисс ажиллаж байна.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн**:

- Зохиогчийн дүгнэлтийг шинэчлэн ирүүлэх
- БТХ-ийн 14.3, 14.6-ийн дагуу чанарын баталгаа гаргах
- Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл дээрх мэдээлэл шинэчлэх (зохиогч, зориулалт)
- Зохиогч нарын хоорондоо хийсэн гэрээг шинэчлэх ирүүлэх
- Жимсний үйлдвэрийн дотор заслыг гүйцээх (фото зураг)

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Г.Батбаатар**:

- Барилгад хэрэглэсэн бетоны шинжилгээг үе шат бүрээр ирүүлэх, Милко барилга, Сүү, сүүн бүтээгдэхүүний барилга, 3 давхар оффис
- 3 давхар, Адапт бюлд, Аж групп ХХК тусгай зөвшөөрөл, Пи Си Ди Пи шилжүүлсэн гэрээ, БАЗГ-ийг тайлбар
- Гадна тохижилт, ногоон байгууламжийг хийх
- Контор боолт хийсэн зургийн фото үзүүлэх, төмөр хийц эхэлсэн

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Бар

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Гадна дулаан, цэвэр, бохир, агаар сэлгэлтийн сорилт туршилт, ил далд ажлын актууд шалгуулах
- Узелийн өрөөнд агаар сэлгэлт хийх
- Үйлдвэр, сүүний үйлдвэрийн агаар сэлгэлтийн системийг зургийн дагуу угсарч дуусгах
- Гадна дулаан, цэвэр, бохир усны шугаманд ашигласан материалын сертификат шалгуулах
- Гадна ус, дулаан, бохир усны шугас хотын мэдээллийн санд оруулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын хэсгийн ахлагч **Б.Дашдорж:**

- Гадна цахилгаан дизель генераторыг ашиглалтанд оруулж, барьж ашиглах засварын төвд бүртгүүлэх
- Ерөнхий шийд, давхрын самбаруудад хаяг, биркжүүлэлт хийх
- 0,4 кв-ийн кабелийн трассыг нийслэлийн мэдээллийн санд оруулах
- Аянга зайлуулах газардуулга хийлгэсэн фото зураг, гүйцэтгэлийг шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилга хөгжлийн төв, Барилга барилгын материал үйлдвэрлэлийн хэлтэсийн инженер **О.Ундрах:**

- Үйлдвэрийн барилгуудын дээврийн прогоны ташуу татлага болон шулуун татлагууд дутуу хийгдсэн байна, гүйцээх
- Металл багануудын анкерын давхар боолтон бэхэлгээ хийсэн далд ажлын акт нөхөж үзүүлэх
- Бетоны бат, бэхийн лабораторийн дүгнэлтийг блок, давхар тус бүрээр нь нөхөж үзүүлэх
- Оффисын барилгын дээврийн мембрамыг өөрчилсөн тухай зохиогчийн нэгдсэн дүгнэлтэд тусгаж ирүүлэх
- Мөн оффисын ил далд ажлын актны фото зургаас үзэхэд барилгын шатны арматурчилалын дээд, доод үеийн шилжилтүүд зураг төслийн дагуу хийгдээгүй байна. Үүн дээр тайлбар зохиогч албан бичиг ирүүлэх
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу норм нормативын төлбөрийг тооцуулж төлөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер **Г.Үүрийнгэгээ:**

- Сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах болон хүнсний үйлдвэрийн 2 блок барилгын хаягдал (технологийн хаягдал) усыг цэвэрлэх, бага оврын цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтанд оруулах
- Үйлдвэрийн доторх шалны траппны улыг гүйцээж хийх, тос баригч, шүүр холбох (хоолойн), хоолойн холболтуудыг гүйцээх

ХЯНА
илга бай
ор

- Гадна цэвэр, бохир усны худгуудын хүзүүвч, кольцо хоорондын битүүмжийг сайжруулах, таг битүүмжийг трассын дагуу шалгаж фото зургаар шалгуулах
- Үйлдвэр доторх технологийн болон унд-ахуйн нөөцийн усан сангийн холболтуудыг гүйцээх, угсралт халдваргүйжүүлэлтийг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаар хийлгүүлж, акт үйлдэж шалгуулах
- Угсралт хийлгүүлнсий дараа НЭМГ-т хүсэлт өгч унд-ахуй усны сорьц өгч, дүгнэлтийг шалгуулах (MNS 0900:2018 хангасан байх) (нян, хамм-физик үзүүлэлт шалгуулах)
- Зохиогчийн дүгнэлтэд тусгагдсан конторын барилгад төлөвлөсөн ажилчдын шүршүүрийн тоог 2 дахин нэмэгдүүлэхээс шалтгаалан усны зарцуулалт хүрэхгүй гэх тайлбар, шалгасан акт шалгуулах (хувийн хэрэг х-138-141)
- Усны тоолуурын хяналтын лац тавиулах, шалгуулах
- Зурагт тусгагдсан (Зоорийн давхарт) бохир усны насос суурилуулах шалгуулах
- Нийтийн АЦӨ-ний эрэгтэй шээлтүүрийг зай хэмжээний талаар тайлбар ирүүлэх, зай хэмжээг стандартын дагуу барьж тоог цөөлөх, хаалтыг хийх
- 83/22, 525/21 тоот техникийн нөхцөлд зөвхөн 1 барилгад олгогдсон учраас УСУГ-т албан бичгээр хандаж, тодруулах
- 22012580 дугаар гэрээг шинэчлэх (сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэр, конторыг салгах)
- 83/22 тоот техникийн нөхцөлийн дагуу гадна цэвэр, бохир усны ажлын батлагдсан зурагтай эсэх шалгуулах
- Дотор цэвэр бохирын шугамын акт шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **Н.Болор-Эрдэнэ**:

- Дотор холбоо дохиоллын дутуу суурилуулсан тоноглолуудыг гүйцээх (Камер, нэвтрэх систем, үйлдвэрийн барилгын зарлах спикер, интернет сүлжнээний разетка)
- Серверийн өрөөнүүдийг хаягжуулах, сүлжээний утаснуудыг хаягжуулах
- Ил далд ажлын дутуу актуудыг гүйцээх (интернет сүлжээ, нэвтрэх систем)

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Нийслэлийн Онцгой байдлын газар, Барилгын зураг төслийн хяналтын байцаагч, хошууч **Б.Даваасүрэн**:

- Гадна дулаалга болон дүүргэгч материалын шинжилгээний дүгнэлт үзүүлэх
- ГК Батлагдсан зургийн дагуу хийх, шалгасан акт
- Галын дохиоллын систем шалгасан акт, фото зураг удирдлагын самбарт зааварчилгаа, зургийн дагуу хийх
- Спринглер систем батлагдсан зургийн дагуу хийх, өөрчлөлтийн зураг хянуулах
- Гидрант төлөвлөх MNS5566:2020 стандартын дагуу

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, ШХХА-ны холболтын инженер **М.Мөнхтөр:**

- Шугам эзэмшигчтэй зөвшилцсөн албан бичиг, зөвшөөрлийг эх хувиар нь үзүүлж шалгуулах
- Техникийн бичиг баримтад узель угсарсан, холигч узель угсарсан актуудыг нөхөж үзүүлэх (хавсаргаж оруулах, албажуулах)
- Холигч узелийн шугамын дулаалга, хаягжуулалт хийх. Цахилгаан тоноглолын үндсэн тэжээлийг оруулж удирдлагын самбарыг холбож ажиллагаанд оруулах
- Батлагдсан зураг төслийн дагуу эрчим төсөл ЭТ-09/2023 түүвэрт тусгагдсан УДДТ-1, УДДТ-2-ын халаалт, халуун ус, салхивчны эргэлтийн насосуудад давтамж хувиргагч VLT нэмэлтээр нөөцөнд угсрах
- Салхивчийн ачаалал авахдаа хангагч байгууллагад хандаж мэдэгдэж аж ахуй гэрээнд нэмэлт хийлгэж, тоноглол иж бүрэн угсрагдаж дууссаны дараа хяналт тавиулан залгах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч **Э.Шижиртуяа:**

- Ил далд ажлын актыг объект тус бүрээр бүрэн бүрдүүлэх
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлд гүйцэтгэгч байгууллага баталгаа гаргах
- Архивд Баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу Баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, Баримт бичгийн хуудас дугаарлах, дотоод товъёог үйлдэх
- Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивд хүлээлгэх өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэний Эрхийг Хамгаалах Байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Ганбаатар:**

- Нийтийн авто зогсоолд ХБХ-н машинд зориулсан зогсоолын өргөн 3м95см тооцож хийнэ. Машин зогсох зам 2м45см, тэргэнцэртэй бууж, суух зай 1м50 өргөн шугам татаж тусгаарлаж өгнө. Зогсоолын урд 1м80см шон 30х45см багагүй самбар байрлуулна.
- Гадна налуу замын 2 талд 65см өндөр 2 бариул хийнэ. 2 бариулын хоорондын зай 90см байна. Бариулын өргөн 3см ихгүй байна.
- 1- р давхрын ажилчдын дүүшны хананд туслах бариул хийнэ. Эм, эр нэг нэг АЦӨ-ний суултуур, нэг босоо шээлтүүр, 2 давхрын эр, эм нэг, нэг кабиныг БНБД 31-23-22 стандартын шаардлага хангасан туслах тоноглолуудыг суурилуулна.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Зураг төсөл зохиогч Аж групп ХХК-н төлөөлөл **Б.Энхболд:**

АЛГАЛТЫН
ЗАР
Эрхийг ашигла
Комисс

